

АЙМГИЙН ИТХУРЛЫН ТОГТООЛ, АЙМГИЙН УДИРДЛАГААС ӨГСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАРЫН БИЕЛЭЛТИЙГ ДҮГНЭСЭН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 12 сарын 08

Дугаар...

Баруун Урт.

ХЭЛЭЛЦСЭН нь:

Хурал 2022 оны 12 сарын 08-ны өдөр 15:20 цагт байгууллагын даргын өрөөнд байгууллагын дарга, сургалтын менежер, багш нийт 6 хүний бүрэлдэхүүнтэй оролцон хуралдаж Насан туршийн боловсрол төвийн дарга М.Энэбиш удирдан эхлэв.

Хэлэлцсэн асуудал:

Танилцуулсан: Багш С.Ганборгил: 2022 оны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт гаргах чиглэлийн хүрээнд аймгийн ИТХурлын тогтоол, аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтийг би гаргаж <http://sukhbaatar.igovernment.mn/> цахим системд оруулж байна.

Энэ онд манай байгууллага хяналтанд байлгах, биелэлт гаргах ИТХурлын Тогтоол 3, аймгийн удирдлагаа өгсөн үүрэг даалгаврын биелэлт 25 зүйл заалт гаргаж байна. /энэ удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлт нь удирдах ажилтны шуурхай хурлын үеэр аймаг орон нутгийн чанартай үүрэг даалгавар байна/

Хэлэлцсэн нь:

Нарийн бичиг: Багш У.Наранжаргал

Дарга М.Энэбиш:

- 2022 онд хяналтанд байлгах, биелэлт гаргах ИТХурлын тогтоол, үүрэг даалгаврыг цахим системд цаанаас нь оруулдаг уу. Манайх аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаварын биелэлтэн дээр их хугацаа хоцрогдолтой байна. Бид яагаад мэдсэнгүй вэ.

Багш С.Ганборгил:

- Төрийн мэдээллийн цахим системд биелэлт гаргах бүх зүйл заалтыг тухайн байгууллагад хамааруулж цаанаа оруулж байна. Үүрэг даалгаврыг өмнө нягтлан бодогч М.Рагчаабазар хариуцдаг байсан. Үүнтэй холбоотой систем нээж харахаас өмнөх бүх үүрэг даалгавар хугацаа хоцорч харагдаж байна.
- Үүрэг даалгаврын биелэлтийг 2022.12.10-ны дотор оруулж дуусгах ёстой.Биелэлт, хавсралт файлуудыг системд оруулсан.

Багш Ч.Уранчимэг:

АИТХурлын тогтоолын биелэлт оны эцсийн байдлаар ямар үнэлгээтэй гарч байна вэ.

Багш С.Ганборгил:

Аймгийн ИТХурлын Тогтоолын биелэлт энэ оны жилийн эцсийн байдлаар 3-н зүйл заалтын хүрээнд 90 хувийн биелэлттэй гарч байна.

Сургалтын менежер П.Уянга:

ИТХурлын тогтоол 90 хувийн биелэлттэй гэхээр ямар зүйл заалтийг бид хяналтанд байлгаж цаашид анхаарах шаардлагатай вэ

Багш С.Ганборгил:

- Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналтын камертай болох тогтоол. Манай байгууллагын хувьд 2 давхарт 2 аналог камер ажиллаж байна. Гадна орчны хяналтын камерыг нэмж ажиллуулах шаардлагатай. Энэ тогтоолын биелэлт 70 хувийн биелэлттэй гарсан.
- Залуучуудын өдрийг зохион байгуулах ажил- 100 хувьтай байна.
- Нутгийн залуучууд хөтөлбөрийн залуучуудын оролцоог хангах зэрэг заалтуудыг 100 хувьтай биелэлтийг дүгнэсэн.

Захирал М.Энэбиш:

Та нарын гаргаж байгаа тайлагналт ерөнхий тоон хувь үнэлгээтэй байна. Бутархай бодит өгч болохгүй юу.

Сургалтын менежер П.Уянга:

- Төрийн мэдээллийн цахим системийн биелэлтийн үнэлгээ өөрөө бүхэл, 5 үе шаттай байна. Бутархай тоогоор үнэлэж болохгүй 100, 70, 30, 0, хугацаа хоцорсон гэж үнэлгээг тавьж байна.

Багш У.Наранжаргал

Төрийн мэдээллийн системд биелэлт гаргахад хавсралт мэдээлэл, гэрчилэх баримтыг оруулж байгаа юу. Баталгаажуулчихвал оруулах боломжгүй болж байгаа гэсэн.

Багш С.Ганборгил:

Аймгийн ИТХурлын Тогтоолын 3-н биелэлтийн гэрчлэх баримтыг зүйл заалт болгоноор текстэн мэдээлэл болон зураг файл хавсаргаж оруулсан. Аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгарын биелэлтийн хүрээнд агуулга, биелэлт хүлээж авах хугацаанаас хамаарч 4-н хавсралт файл оруулсан.

Нийгмийн ажилтан А.Батбаатар:

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт 25-н зүйл заалт бүхий үүрэг даалгавар байна гэсэн ямар утга бүхий үүрэг даалгавар байна. Бидний гаргаж байгаа биелэлттэй холбогдох уу.

Захирал М.Энэбиш:

- Аймгийн удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт нь удирдах ажилтны шуурхайд дээр аймаг орны чанартай үүрэг даалгавар байна лээ. Би биелэлтэнд хяналт хийж баталгаажуулахад бэлэн байна.

Захирал М.Энэбиш:

- Төрийн мэдээллийн системд биелэлтийг баталгаажуулахаас өмнө зөв бичгийн дүрэм болон утга найруулгын алдааг сайн хараарай. Болсон гэвэл баталгаажуулахад бэлэн.

Байгууллагын ИТХурлын Тогтоол болон удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хэлэлцэх хурал 15:45 цагт дуусав.

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

У.НАРАНЖАРГАЛ